



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.08 № 01/817  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-  
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ГОМБООГИЙН НЭРГҮЙ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Гомбоогийн Нэргүйн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Гомбоогийн Нэргүйн Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Гомбоогийн Нэргүйн сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Гомбоогийн Нэргүйд

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГОМБОО ОВОГТОЙ НЭРГҮЙ  
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ:Ерөнхий агуулга

Сум орон нутгийн онцлог, байгаль цаг уурын нөхцөл, хүн ардын аж амьдралын хэв маяг зэргийг харгалзан хүн ардад ээлтэй өрх гэр бүлийн хөгжлийг дэмжсэн өв соёлоо хадгалсан, хөдөө аж ахуйд тулгуурласан байгалийн нөөцөд түшиглэсэн, аялал жуулчлалыг дэмжсэн орон нутаг болно гэсэн эрхэм зорилгыг баримталж, иргэдийн аж байдал амьдрах орчныг сайжруулахад чиглэнэ.

ХОЁР: Хөтөлбөрийн үндсэн заалт

1.Өрхийн хөгжлийг дэмжих, орлого нэмэгдүүлэх чиглэлээр

- Жижиг үйлдвэр үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийг орон нутгийн бодлогоор дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулах талаар санаачилж ажиллана.
- Цөөн малтай малчин өрхийг “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т болон “Чинээлэг малчин” хөтөлбөрт хамааруулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- Өрхийн түвшинд хүнсний ногоо, хүлэмж, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлж, нэр төрлийг олшруулах бодлогыг дэмжиж ажиллана.
- Зөгийн аж ахуйг дэмжин, бүлийн тоог нэмэгдүүлэх, шинэ зоорь барих, зөгийчдийн холбоодтой холбох зэрэг ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- Малчдын бүлэг, хуримтлалын бүлгийн ололт туршлагыг улам дэлгэрүүлж, иргэдээс гарсан үүсэл санаачилгыг дэмжиж ажиллана.
- “Чандмань” брэнд үзэсгэлэн худалдааг тогтмолжуулж, Мөрөн, Эрдэнэт, Улаанбаатар зэрэгт бүтээгдэхүүнийг борлуулах, орлогыг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- Малчин өрхийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, орон сууц, хашаа, хадлангийн талбайг хамгаалахад мод, модон материал олгогдох нөхцөлийг сайжруулах талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэхийн төлөө ажиллана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Г.НЭРГҮЙ

